

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

ХҮСНЭГТ 3.7

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	<p>Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх:</p>	<p>Төвийн хэмжээнд мөрдөн ажиллаж буй бодлогын баримт бичиг /төвийн эрхэм зорилго, алсын хараа, чанар, ХЭМАБ-ын бодлого, зорилт/-үүдийг хэрэгжүүлэхээр хийгдэж буй үйл ажиллагаа, үр дүн, статистик мэдээллийг цаг тухай бүрт цахим хуудас www.donor.mohs.mn/ мэдээллийн/ 1, 2 дугаар байрны мэдээллийн самбар, ХЭМАБ-ын самбар, Ёс зүйн салбар хороон самбар, Сувилахуйн албаны самбар, Шилэн дансны ил тод байдал /болон цахим/ 1, 2 дугаар байрны 3 самбаруудад чиглэл тус бүрээр тогтмол шинэчлэн байршуулдаг.</p> <p>Төвийн нийт ажиллагсад дотоод сүлжээнд байрлуулсан санал солилцох цэс, лан мессенжер ашиглан үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хугацаа алдахгүй солилцон ажиллаж байна</p> <p>Цахим хуудасны танилцуулах хэсэгт: Төвийн эрхэм зорилго, алсын хараа, ЭМС-ын 2020 оны А/445 тоот тушаалаар батлагдсан төвийн бүтцийн схемийг байрлуулсан.</p>	100%

		<p>Мэдээ мэдээлэл хэсэгт: 2021 онд зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол байршуулсан бөгөөд 12 хуудас 100 гаруй төрлийн мэдээ, мэдээлэл нийтлэгдсэн байна.</p> <p>Төвийн I, II байранд нийт 8 мэдээллийн самбарыг байгууллагын брендбүүкийн дагуу хийж байршуулан, тушаал шийдвэр,</p> <p>үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллуулж байна.</p>	
2.	<p>Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар тухай бүр шинэчлэх:</p>	<p>Тус төвийн Ерөнхий захирлын баталсан хуваарийн дагуу донор, үйлчлүүлэгчдийг хүлээн авч, уулздаг бөгөөд биечлэн ирсэн үед хуваарь харгалзахгүй хүлээн авдаг.</p> <p>Цахим хуудасны ил тод байдал цэсэнд: Донор, үйлчлүүлэгчдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг 2021.01.10-ны өдөр төвийн Ерөнхий захирлаар батлуулан, захидал харилцааны асуудал хариуцсан ажилтны овог, нэр, өргөдөл гомдол хүлээн авах утасны дугаар болон и-мэйл хаягыг байршуулсан.</p> <p>Дээрх хуваарийг I, II байрны донорын үйлчилгээний хэсгийн мэдээллийн самбарт болон угтах хэсэгт байршуулсан ба Иргэдээс ирсэн өргөдөл гомдолийн тайланг байршуулсан байна.</p>	100%
3	<p>Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа</p>	<p>Тус төв нь донор үйлчлүүлэгчиддээ зориулан үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалт, доноруудад зориулсан зөвлөгөө мэдээллийг төвийн цахим хуудас www.donor.mohs.mn/, Цус сэлбэлт судлалын үндэсний төв,</p>	100%

	<p>ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх:</p>	<p>Амьдрал бэлэглэе пейж хуудсуудад байршуулан 14 хоног тутам зөвлөгөө, зөвлөмжийг шинэчлэн ажиллаж байна.</p> <p>Цахим хуудасны бүтээгдэхүүн үйлчилгээ цэсний, донор танд хэсэгт:</p> <p>Донорт тавигдах шалгуур, цус өгөхийн өмнөх болон цус өгсний дараах зөвлөмж, төлбөрт үйлчилгээ авахад шаардлагатай бичиг баримтын жагсаалт зэрэг 42 төрлийн мэдээлэл, зөвлөгөө байршуулан донор үйлчлүүлэгчдийг мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Баянзүрх, Сүхбаатар, Дүнжингарав цус цуглуулах төвүүдэд 2 цахим самбар, 7 телевиз ажиллуулан донорын шалгуур, зөвлөмж, үйлчилгээнд мөрдөгдөх дүрэм, журам, үйлчилгээ үзүүлж буй эмч, мэргэжилтнүүдийн мэдээлэл зэргийг байршуулан, шилэн данс-ил тод байдлын самбар, байгууллагын үйл ажиллагааны, ХЭМАБ-ын болон үйлдвэрчний эвлэл, ёс зүйн салбар хорооны үйл ажиллагааг үйлчлүүлэгч, эмч ажилтанд мэдээлэх самбар, санал хүсэлтийн хайрцаг, хандивын хайрцгийг төвийн брэндбүүкийн дагуу шинээр хийж байршуулан холбогдох ажилтан мэдээ, мэдээллийг өгч ажиллаж байна.</p>	
4	<p>Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой</p>	<p>Тус төв нь Монгол улсын 60 хууль, тогтоомж, 7 стандарт, Засгийн газрын 11 тогтоол, ЭМ-ийн сайдын 60, Сангийн сайдын 2, Хөдөлмөрийн сайдын 1, Төвийн Ерөнхий захирлын 122 тушаал, 51 журам, 11 үйл явцын тодорхойлолт, 76 САЗ, 29 ТТАЗ, 27 АЗ, 123 маягт, 26 хяналтын хуудсыг үйл ажиллагаандаа</p>	100%

	байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх:	хэрэгжүүлэн баримт бичгийн нэгдсэн жагсаалт гарган ажиллаж байна. Цахим хуудасны эрх зүй цэсэнд: Төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй 58 хууль тогтоомж, түүний жагсаалт, УИХ-ын 2 тогтоол, Засгийн газрын 11 тогтоол, Засгийн газрын болон Эрүүл мэндийн сайдын албан даалгавар 24, Эрүүл мэндийн сайдын 60, төвийн захирлын 122 тушаал холбогдох дүрэм, журмыг байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	
5	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн иргэдийн саналыг авах, үндэслэлтэй, гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах,	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төсөл 2021 онд байгаагүй болно.	
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх:	<ul style="list-style-type: none"> Лабораторит нэвтрүүлсэн 5 төрлийн тоног төхөөрөмжийг ажиллуулахад шаардлагатай урвалж оношлуурын захиалгыг төвийн төсөвт тусган ажилласан. 2020 онд Cobas s 201 хуучин PCR аппаратаар нийт шинжилгээний 80%-ийг хийж байсан бол 2021 онд шинээр нэвтрүүлсэн PCR 6800 тоног төхөөрөмжөөр нийт шинжилгээний 85%-ийг хийж урьд жилийнхээс 65%-р нэмэгдүүлсэн. Bact/Alert 	100%

		<p>аппарат, Бүлэгнэлтийн CS 2400 аппаратаар 100% чанарын шинжилгээг хийсэн. HISCL 5000 аппаратаар 3500 сорьцонд шинжилгээ хийж урьд жилийнхээс 50%-р нэмэгдсэн. Иммукор аппаратаар цусны ABO, резус, келл бүлэг, резусын дэд бүлгүүд тодорхойлох шинжилгээг нийт сорьцын 25%-д хийж өмнөх жилийнхээс 10%-иар нэмэгдүүлсэн</p> <ul style="list-style-type: none"> • 2021 оноос эхлэн SARS-COV-2 Эсрэгбие агуулсан эмгэгтөрүүлэгчийг идэвхгүйжүүлсэн сийвэн бэлтгэж эхэлсэн. Нийт 303 нэгж бүтээгдэхүүн бэлтгэсэн ба халдварт өвчин судлалын үндэсний төвд хэвтэн эмчлүүлж байгаа ковид-19 хүнд өвчтөнд эмчилгээнд хэрэглэж байна. • ХЭМАБ-ын баримт бичиг хянан 2021 оны хугацаа дуусч буй 15 журмыг Төвийн баримт бичиг хянах журмын дагуу сунгаж баримтжуулан, байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрээр ХЭМАБ баримт бичиг, журам, заавар, зөвлөмжийг байршуулсан. • ЭМС-ын тушаал, УОК-ын шийдвэрүүдийн дагуу ХСХ, Тохиолдлын журмууд шинэчлэгсэн. • ХЭМАБ-ын Удирдлагын тогтолцоо-шаардлага MNS OHSAS 18001:2012 стандартаас ISO 45001:2018 стандарт руу шилжих бэлтгэл ажлыг хангах ажлыг хүрээнд ХЭМАБ-ын зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2021 оны 03 сарын 31-ний өдрийн Ерөнхий захирлын тушаалаар шинэчилж, 6 ажлын төлөвлөн бэлтгэл ажлыг хангасан. • Олон улсын стандартын Академи"-тай гэрээ байгуулж Зөвлөлийн гишүүд болон нийт 18 эмч ажиллагсдыг ISO45001:2018 танилцуулах модуль 1, 2, 3 сургалтанд хамруулж, давхардсан тоогоор 34 хүн гэрчилгээ авсан. • “Цус сэлбэлт судлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт Эрдэм шинжилгээний XVIII бага хурлыг 9 дүгээр сарын 11-нд танхим болон цахим гэсэн хосолсон хэлбэрээр зохион байгуулж, нийт 12 илтгэлийг хэлэлцүүлсэн. • 2021 оны 3 дугаар сарын 25-нд “Цусны аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт Үндэсний цахим семинарыг зохион байгуулж, Цусны салбар төвийн 22, төвийн 20 нийт 42 эмч, мэргэжилтэнг хамруулсан. Цахим семинариар Цусны салбар 	
--	--	---	--

		<p>төвүүдийн 2020 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, санал зөвлөмж өгсөн.</p> <ul style="list-style-type: none"> • Байгууллагын интернетийг сайжруулах ажлыг зохион байгуулж ажилласан. БЗЦЦТ-ийн интернетийн хурдыг 6 мегабайтаас 10 мегабайт, СБЦЦТ-д 3 мегабайтаас 6 мегабайт болгон нэмэгдүүлснээр БЗЦЦТ-ийн интернетийн хурд 40%, СБЦЦТ-ийн интернетийн хурд 50%-иар тус тус нэмэгдсэн. • Төвийн 3 байрны хэмжээнд 68 хяналтын камер суурилуулсаны 13 нь гадаад орчинд, 55 нь дотоод орчинд байршуулж, хяналтын дэлгэцийн тохиргоонд байнга хянах шаардлагатай 16 камерыг холбон камерын хяналтын системийг өргөжүүллээ. БЗД-ийн хяналтын камерын бичигч төхөөрөмжийг үзүүлэлт өндөртэй бичигчээр сайжруулж тохиргоог хийсэн. • Гаднах талбайд эмнэлгийн машины зогсоол байгуулан таних тэмдэг тавьж байршуулсан. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг ханган гадна гэрэлтүүлгийг цагийн тохируулгатай тогтмол ажиллагаатай байлгах, шатны бариулуудыг будах, халтиргаа гулгаанаас сэргийлж гишгүүр байршуулах, бохир, цэвэр улавч ангилан ялгаж хийх зориулалтын хайрцаг санаачлан хийж ажиллалаа. 	
7.	<p>Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим</p>	<p>2021 оны байдлаар төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгээгүй.</p>	100%

	хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар мэдээлэх:		
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр хаяг эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх:	Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогддоггүй.	100%
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудасдаа байрлуулан тухай бүр шинэчлэх:	“Нарлаг Улаанбаатар Ротари” клуб Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтарч Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийг ашиглан цус, цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэх “REDrone” (Red drone) төслийг санаачилсан бөгөөд “Цус тээвэрлэх анхны нислэг”-ийн нээлтийн ажиллагааг амжилттай зохион байгуулсан талаар мэдээлэл цахим хуудасдаа байрлуулан.	100%
		Хэсгийн дундаж хувь	100%
Хоёр.Хүний нөөцийн ил тод байдал			
№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа	Хүний нөөцийн нөхөн хангалтыг 95-100 хувьтай бүрдүүлж ажилласан. Оны эхнээс 5 ажилтанд жирэмсэний болон амаржсаны амралт олгож 2	100%

	ойлгомжтой байдлаар тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах:	ажилтныг өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор шилжүүлж, 5 ажилтныг өөрийн хүсэлтээр, 5 ажилтныг туршилтын хугацаанд чөлөөлөв. Zangia.mn сайт, байгууллагын цахим хуудсаар сул ажлын байрны зар байрлуулж, 9 ажилтныг туршилтын хугацаагаар томилсноос 4 ажилтан жинхлэн болон түр хугацаанд томилогдож, хүүхэд асрах чөлөөтэй байсан 5 ажилтныг ажилд нь томилсон.	
2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх:	Байгууллагын donog.mohs.mn вэб сайтад Ёс зүйн салбар хороо дэд цэс байрлуулан тайлан, холбогдох дүрэм, ЁЗСХ-ний бүрэлдэхүүн, санал, гомдол, мэдээлэл гаргах хаягт, утасны дугаар, санал, гомдлын хэсгийг тус тус байрлуулсан.	100%
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх.	Байгууллагын donog.mohs.mn вэб сайтад Ил тод байдал дэд цэс байршуулан түүнд Хүний нөөцийн хөгжлийг хангах хөтөлбөр 2021-2026, Хүний нөөцийн төлөвлөлтийг тус тус шинэчлэн байршуулсан.	100%
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах, чиглэлээр авч байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх	Хүний нөөцийн нөхөн хангалтыг Zangia.mn сайт, байгууллагын цахим хуудсаар сул ажлын байрны зар байрлуулж, 9 ажилтныг туршилтын хугацаагаар томилсноос 4 ажилтан жинхлэн болон түр хугацаанд томилогдож, хүүхэд асрах чөлөөтэй байсан 5 ажилтныг ажилд нь томилсон.	100%

	<p>Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв шударга, болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх:</p>	<p>Алба хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх ЗГ-ын 2019 оны 38 дугаар тогтоолыг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээлж байна.</p>	<p>100%</p>
	<p>Хэсгийн дундаж хувь:</p>		<p>100%</p>
	<p>Хэрэгжилтийн дундаж хувь:</p>		<p>100%</p>